



## ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК

15 дугаар давхар, Моннис тауэр, Чингисийн өргөн чөлөө 15,  
1 дүгээр хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14240  
Утас: 7555 3399, Цахим шуудан: info@erdenesmongol.mn,  
Цахим хуудас: www.erdenesmongol.mn, УБД: 9011014002

2024.01.16 № 04/60

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Ажлын даалгаварт нэмэлт орсон тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 заалт, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын А/103 дугаар тушаалыг үндэслэн 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний тодотголд тусгаснаар төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлэх шийдвэр гарсан.

А/103 тушаалаар батлагдсан ЭМГЛ/20231126 тендер шалгаруулалтын дугаартай “Асгатын мөнгөний ордын нөөцийг олон улсын нөөц баялгийн /jorc/ ангилалд нийцүүлэх хайгуулын ажлын төлөвлөгөө боловсруулан түүний дагуу нэмэлт хайгуулын ажил гүйцэтгэх, хагас үйлдвэрлэлийн технологийн туршилт хийх, үр дүнгийн тайлан боловсруулж батлуулах” төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх эрхийг танай газарт шилжүүлсний дагуу 2023 оны 11 дүгээр сарын 13-нд нээлтэй тендер шалгаруулалтын журмаар зарлаж амжилтгүй болсон.

“Худалдан авах ажиллагааны техникийн тодорхойлолт боловсруулах аргачлалд” нийцүүлэн ажил гүйцэтгэгчийн гүйцэтгэх ажлын суурь түвшнийг тодорхой болгох зорилгоор хайгуулын ажлын шатанд гүйцэтгэх өрөмдлөг болон суваг малталт, далд нэвтрэлтийн ажлын хэмжээг ажлын даалгаварт дараах байдлаар нэмж оруулсан.

#### Өрөмдлөг, уулын ажил:

- Гадаргуугийн өрөмдлөгийн ажил 5000 тууш метрээс дээш гүйцэтгэх.
- Далд өрөмдлөгийн ажил 3000 тууш метрээс дээш гүйцэтгэх.
- Суваг малталт 6000 куб метрээс дээш гүйцэтгэх.
- Далд нэвтрэлт 1000 тууш метрээс дээш гүйцэтгэх.

Иймд шинэчлэн баталсан ажлын даалгаврын дагуу худалдан авах ажиллагааг холбогдох хууль журмын хүрээнд шуурхай зохион байгуулж өгнө үү.

Хавсралтаар төсөл арга хэмжээний ажлын даалгаврыг хүргүүлэв.

Хавсралт № хуудастай.

САНХҮҮГИЙН НЭГДСЭН УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН АХЛАХ МЕНЕЖЕР



Б.БАТБАЯР

1424060101



**БАТЛАВ:**  
ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК-ИЙН  
САНХҮҮГИЙН НЭГДСЭН УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН АХЛАХ МЕНЕЖЕР

  
Б. БАТБАЯР

АСГАТЫН МӨНГӨНИЙ ОРДЫН НӨӨЦИЙГ ОЛОН УЛСЫН НӨӨЦ БАЯЛГИЙН /JORC/  
АНГИЛАЛД НИЙЦҮҮЛЭХ ХАЙГУУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАН  
ТҮҮНИЙ ДАГУУ НЭМЭЛТ ХАЙГУУЛЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ, ХАГАС ҮЙЛДВЭРЛЭЛИЙН  
ТЕХНОЛОГИЙН ТУРШИЛТ ХИЙХ, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН БОЛОВСРУУЛЖ БАТЛУУЛАХ  
АЖЛЫН ДААЛГАВАР

№	Ажлын нэр, төрөл	<p><b>Ажлын нэр:</b> Асгатын мөнгөний ордын нөөцийг олон улсын нөөц баялгийн /jorc/ ангилалд нийцүүлэх хайгуулын ажлын төлөвлөгөө боловсруулан түүний дагуу нэмэлт хайгуулын ажил гүйцэтгэх, хагас үйлдвэрлэлийн технологийн туршилт хийх, үр дүнгийн тайлан боловсруулж батлуулах.</p> <p><b>Төрөл:</b> Ажил</p>
1	Захиалагч байгууллагын нэр, хаяг	<p>Монгол Улс, Улаанбаатар хот-14240, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн байр (Вэб сайт: <a href="http://www.erdenesmongol.mn">www.erdenesmongol.mn</a>), (Имэйл хаяг: <a href="mailto:info@erdenesmongol.mn">info@erdenesmongol.mn</a>)</p>
2	Төсөл хэрэгжүүлэх талбай	<p>Баян-Өлгий аймаг, Ногооннуур сум, Асгатын мөнгөний орд</p>
3	Ажил гүйцэтгэх үндэслэл	<p>Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 06 дугаар сарын 12 өдрийн 35 дугаар тэмдэглэл болон Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.1.5-д “Асгатын мөнгөний ордыг ашиглалтад бэлтгэх, эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийх, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх” гэж тусгасан.</p> <p>Асгатын мөнгөний ордод 1976–1991 онд геологи, гидрогеологи, эрэл-үнэлгээ, урьдчилсан хайгуулын ажлууд хийгдсэн эдгээр ажлуудыг нэгтгэн боловсруулж 1996 онд В.П.Грязнов, А.Аманбек, С.Жарганат нар мөнгө болон дагалдах бүрэлдэхүүний нөөцийн тооцоо хийж тухайн үеийн ашигт малтмал хүлээн авах зааврын дагуу Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр батлуулсан боловч ордыг ашиглахаар боловсруулагдан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн техник-эдийн засгийн үндэслэл өнөөг хүртэл хийгдээгүй байна.</p> <p>Өмнө хийгдсэн хайгуул, эрэл-үнэлгээний ажлууд, нөөцийн тооцоог хянан баталгаажуулан, Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ашигт малтмалын нөөцийн ангилал болон олон улсын нөөц баялгийн /JORC/ стандартад нийцүүлэх шаардлага гарсан.</p>
4	Ажлын хэмжээ	<p><b>Хайгуулын мэдээлэл цуглуулах:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Исэлдсэн бүсийн түвшинг нарийвчлан тогтоох.</li> <li>- Хүдрийн болон агуулагч чулуулгийн бат бэх, тогтворжилтын судалгаа хийх.</li> <li>- Хүдрийн хатуулгийг судлах.</li> <li>- Хүдрийн баяжицыг бүрэн судлах.</li> <li>- Овоолго, хаягдлын аж ахуй, үйлдвэр, тосгон барих талбайнуудын хөрсний инженер-геологийн (геотехникийн) судалгаа.</li> <li>- Хайгуулын ажлаар зөвхөн хүдрийн нөөц тогтоохоос гадна уулын олборлох-боловсруулах үйлдвэр (Уулын баяжигдах үйлдвэр, эсвэл Уул-химийн үйлдвэр)</li> </ul>



		<p>барихад шаардлагатай бүхий л суурь өгөгдлүүдийг цуглуулах.</p> <p><b>Өрөмдлөг, уулын ажил:</b>  Өрөмдлөг, уулын ажлыг төслийн ерөнхий геологич удирдан явуулах ба өрөмдлөгийн ажилд баримтлах үйл ажиллагааны зааврыг боловсруулж нэг бүрчлэн мөрдүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Гадаргуугийн өрөмдлөгийн ажил 5000 тууш метрээс дээш гүйцэтгэх.</li> <li>- Далд өрөмдлөгийн ажил 3000 тууш метрээс дээш гүйцэтгэх.</li> <li>- Суваг малталт 6000 куб метрээс дээш гүйцэтгэх.</li> <li>- Далд нэвтрэлт 1000 тууш метрээс дээш гүйцэтгэх.</li> </ul> <p><b>Дээжлэлт, сорьцлолт:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Өрөмдлөг болон малталт нэвтрэлтүүдээр нэвтэрч хувирал, эрдэсжилт, хүдэржилт бүхий хэсгүүдээс зохих шаардлагын дагуу дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд хамруулна.</li> <li>- Техникийн сорьцлолт түүхий эдийн физик механик шинж чанарыг тодорхойлох, хүдрийн биетийг олборлох дизайн тогтоох, хөрсийг зам барилгад хэрэглэх, чулуулгийн зарим петрогрфийн төрлийг боловсруулахгүйгээр аж үйлдвэрт хэрэглэх боломжийг тодорхойлно. Ордын нөөц бодоход зайлшгүй шаардлагатай хүдрийн эзлэхүүн жин, чийг тодорхойлох ажилбарууд хамаарна.</li> <li>- Технологийн сорьцлолт эрдсийн түүхий эдийн технологийн шинж чанарыг тодорхойлох, түүнийг боловсруулах технологийн схем, горим сонгон авах зорилготой явуулна.</li> </ul> <p><b>Керний геологийн бичиглэл:</b> Бүх цооногийн кернд геологийн бичиглэл хийх.  Керний гарц 95%-аас дээш байх.</p> <p><b>Бусад судалгаа:</b>  Бүх цооногт керний байрлалын чиглэл (core orientation) тогтоох.  Цооногийн хазайлт (survey) 30-50 м тутамд хэмжинэ.  Бүх керний дээжинд RQD болон геотехникийн бичиглэл хийх.  Шаардлагатай хэсгүүдэд цооногийн геофизикийн хэмжилт хийх.</p>
5	Ажлын гүйцэтгэх үе шат, цар хүрээ	<p><b>Гүйцэтгэх ажил:</b></p> <p><b>1 дүгээр үе шат:</b> Хянан баталгаажуулалт, төлөвлөгөө боловсруулах  Тендерийн техникийн саналаар ирүүлсэн JORC стандартад нийцүүлсэн хайгуулын ажлын төлөвлөгөөнд захиалагчийн саналыг харгалзан нарийвчлан боловсруулж захиалагчаар батлуулах.</p> <p><b>1.1</b> Геологийн мэдээллийн сангийн хяналт баталгаажуулалт</p> <ul style="list-style-type: none"> <li>- 1996 онд хийгдсэн Аманбек нарын нөөцийн тайлан дахь дээжлэлтийн хянан баталгаажуулалт</li> <li>- Эзлэхүүн жин</li> <li>- Өгөгдлийн сангийн менежмент</li> <li>- Цооногийн амсрыг тоготой харьцуулсан харьцуулалт</li> <li>- Литологийн мэдээллийн хянан баталгаажуулалт</li> <li>- Чанарын мэдээллийн хяналт баталгаажуулалт</li> <li>- Суваг малталтын мэдээллийн хянан баталгаажуулалт</li> <li>- Хэвтээ малталтын ахилт, дээжлэлтийн хянан баталгаажуулалт</li> </ul> <p><b>1.2</b> Ордын геологийн моделийн хянан баталгаажуулалт</p>



- Геологийн моделийн баримтжуулалт
- Геологийн моделийн өгөгдөл
- Загварчлал хийх аргачлал
- Геологийн моделийн параметрууд
- Чанарын тооцоо, загварчлал
- Загварчлалын шалгалт, баталгаажуулалт

**1.3 JORC стандартад нийцсэн хайгуулын ажлын төлөвлөгөө**

- Хайгуулын аргачлал
- Өрөмдлөг, уулын ажил
- Кернийн бичиглэл
- RQD-ийн бичиглэл
- Геотехникийн бичиглэл
- Цооногийн геофизикийн хэмжилт
- Маркшейдерийн хэмжилт
- Дээжлэлтийн чанар
- Дээжийн чанарын шинжилгээ
- Лабораторийн шинжилгээ
- Лабораторийн хяналт
- Цаашид хийгдэх хүдрийн чанарын туршилтын ажлууд
- Баяжигдах шинж чанар, технологийн туршилтын ажил
- Геотехник, инженер-геологийн судалгаа
- Гидрогеологийн судалгаа
- Геоэкологийн болон бусад судалгаа
- Хайгуулын ажлын нөхөн сэргээлт
- Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа
- Хайгуулын ажлын төсөв

**2 дугаар үе шат:** JORC стандартад нийцсэн хайгуулын ажил, лабораторийн шинжилгээ

**2.1** Хайгуулын ажлыг 1 дүгээр үе шатад боловсруулан захиалагчаар баталгаажуулсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ.

**2.2** Лабораторийн ажил

- Лабораторийн шинжилгээ
- Лабораторийн хяналт
- Хүдрийн чанарын туршилтын ажлууд
- Баяжигдах шинж чанар, технологийн туршилт

**2.3** Хагас үйлдвэрлэлийн технологийн дээжлэлт, туршилт судалгаа /Олон улсад итгэмжлэгдсэн лабораторид хийлгэх/.

Хүдрийн технологийн шинж чанарын судалгааг лабораторийн болон үйлдвэрлэлийн нөхцөлд минералогитехнологийн, бага технологийн, лабораторийн, томсгосон лабораторийн, хагас үйлдвэрлэлийн технологийн сорьцуудаар явуулна.

Хагас үйлдвэрлэлийн технологийн туршилт нь лабораторийн болон томсгосон лабораторийн технологийн үр дүнг хянаж, баталгаажуулах зорилготой.

Хагас үйлдвэрлэлийн технологийн туршилтыг ордын хайгуул эрхэлж буй байгууллага болон технологийн туршилт явуулах байгууллагатай хамтран боловсруулсан хөтөлбөрийн дагуу явуулна.

**3 дугаар үе шат:** Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нөөцийн ангилал, олон улсын нөөц баялгийн /JORC/ стандартад нийцүүлсэн нөөцийн тайлан.

**3.1** Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй "Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн



		<p>ашигт малтмалд хэрэглэх боловсруулж ЭБМЗ-ийн батлуулах.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Оршил</li> <li>- Талбайн ерөнхий мэдээлэл</li> <li>- Талбайн геологийн тогтоц</li> <li>- Ажлын арга, аргачлал, ажлын хэмжээ</li> <li>- Талбайн үнэлгээ</li> <li>- Ордын бодисын найрлага, технологийн шинж чанар</li> <li>- Ордын гидрогеологи, геотехник-инженер геологи</li> <li>- Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн тооцоо</li> <li>- Ордын уул техникийн нөхцөл, эдийн засгийн урьдчилсан үнэлгээ</li> <li>- Ашигт малтмалын ордыг ашиглалтад бэлдсэн байдал</li> <li>- Археологи, палеонтологийн судалгаа, байгаль орчны геозкологийн үнэлгээ</li> <li>- Дүгнэлт</li> </ul> <p><b>3.2</b> Олон улсын нөөц баялгийн /JORC/ стандартад нийцүүлсэн нөөцийн тооцоолол, үр дүнгийн тайлан</p> <ul style="list-style-type: none"> <li>- Олон улсын нөөц баялгийн тооцоолол хийх эрх бүхий /JORC/-ийн итгэмжлэгдсэн мэргэжилтнүүдээр шинжээчийн дүгнэлт гаргуулах</li> <li>- Олон улсын /JORC/ стандартад нийцсэн тайланг боловсруулан баталгаажуулах (/JORC-д итгэмжлэгдсэн, эрх бүхий этгээд)</li> </ul>	<p>аргачилсан зөвлөмж” -ийн дагуу хуралдаанаар хэлэлцүүлэн</p>
6	Хамрах хүрээ	<p><b>Хавсралт-1:</b> Ордын хэвтээ малталтуудын зураг  <b>Хавсралт-2:</b> Нөөцийн дэвсгэр зураг  <b>Хавсралт-3:</b> Ордын хэмжээнд хийгдсэн судалгааны ажлын тайлан, материалын жагсаалт</p>	
7	Ажил гүйцэтгэх хугацаа	<p><b>1 дүгээр үе шат:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хянан баталгаажуулалт  <i>Эхлэх хугацаа: гэрээ байгуулсан өдөр</i>  <i>Гүйцэтгэх хугацаа: 30 хоног</i></li> </ul> <p>Тендерийн техникийн саналаар ирүүлсэн JORC стандартад нийцүүлсэн хайгуулын ажлын төлөвлөгөөнд захиалагчийн саналыг харгалзан нарийвчлан боловсруулж захиалагчаар батлуулах</p> <p><i>Эхлэх хугацаа: гэрээ байгуулсан өдөр</i>  <i>Гүйцэтгэх хугацаа: 3 сар</i></p> <p><b>2 дугаар үе шат:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хээрийн судалгаа, нэмэлт хайгуулын ажил, технологийн дээжлэлт. Лабораторийн шинжилгээ, хяналт туршилт.  <i>Эхлэх хугацаа: 1 дүгээр үе шат буюу төлөвлөгөө баталгаажсаны дараа</i>  <i>Гүйцэтгэх хугацаа: 12 сар</i></li> </ul> <p><b>3 дугаар үе шат:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Суурин боловсруулалт, үр дүнгийн тайлан боловсруулах.  <i>Эхлэх хугацаа: 2 дугаар үе шат буюу хээрийн судалгаа, нэмэлт хайгуулын ажил, технологийн дээжлэлт дууссанаар</i>  <i>Гүйцэтгэх хугацаа: 10 сар</i></li> <li>- Хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт  <i>Эхлэх хугацаа: үр дүнгийн тайлан боловсруулж дууссанаар</i></li> </ul>	



		<p><i>Гүйцэтгэх хугацаа: 30 хоног</i></p> <ul style="list-style-type: none"> <li>- ЭБМЗ-ийн хуралдаанаар шинэчилсэн нөөц батлуулах <i>Эхлэх хугацаа: Шинжээчийн дүгнэлт гарснаар</i> <i>Гүйцэтгэх хугацаа: 60 хоног</i></li> <li>- Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нөөцийн ангилал болон олон улсын нөөц баялгийн /JORC/ стандартад нийцүүлсэн үр дүнгийн тайланг захиалагчид хүлээлгэн өгч гэрээ дүгнэх <i>Эхлэх хугацаа: ЭБМЗ-ийн хуралдааны дүгнэлт, тушаал гарснаар</i> <i>Гүйцэтгэх хугацаа: 20 хоног</i></li> </ul> <p><b>Жич:</b> Ажил гүйцэтгэх хугацааг календарийн хоногоор тооцсон болно.</p>
8	<b>Шаардлагатай багаж хэрэгсэл, техникийн хангамж</b>	Ажилд шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, программ хангамжтай байх.
9	<b>Шаардлагатай боловсон хүчин</b>	<p><b>Багийн ахлагч:</b> 15-аас доошгүй жил геологи, эрэл-хайгуул, нөөцийн тооцоо боловсруулах чиглэлээр ажилласан туршлагатай, Монгол Улсын зөвлөх эсвэл мэргэшсэн зэрэгтэй байх</p> <p><b>Багийн зөвлөх инженер:</b> 10-аас доошгүй жил далд уурхайн ашиглалт, үйл ажиллагааны чиглэлээр судалгаа шинжилгээ, зураг төсөл, ТЭЗҮ боловсруулж байсан туршлагатай байх. Уул уурхайн чиглэлээр Монгол Улсын зөвлөх эсвэл мэргэшсэн инженер зэрэгтэй байх. <b>Нөөцийн ахлах геологич:</b> 10-аас доошгүй жил хайгуул судалгаа хийх, нөөцийн тайлан тооцоо боловсруулах чиглэлээр ажилласан туршлагатай зөвлөх эсвэл мэргэшсэн зэрэгтэй байх.</p> <p><b>Геологич:</b> 5-аас доошгүй жил хайгуул судалгаа хийх, нөөцийн тайлан тооцоо боловсруулах чиглэлээр ажилласан туршлагатай геологичтой байх.</p> <p><b>Баяжуулалтын инженер:</b> Металл ашигт малтмалын баяжуулалт, боловсруулалтын туршилт судалгаа зураг төсөл боловсруулах чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх.</p> <p><b>Гидрогеологич:</b> 5-аас доошгүй жил гидрогеологийн хайгуул нөөцийн судалгааны чиглэлээр ажилсан туршлагатай. Гидрогеологич мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх.</p> <p><b>Геотехникийн инженер:</b> 5-аас доошгүй жил геотехникийн чиглэлээр ажилласан байх.</p> <p><b>Маркшейдер инженер:</b> 5-аас доошгүй жил маркшейдерийн хэмжилт, зураглал хийж байсан.</p>
10	<b>Ажлын үр дүн</b>	<p>“Эрдэнэс Монгол” ХХК-д дараах материалыг хүлээлгэн өгнө.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Асгатын мөнгөний ордын нөөцийн тайлангийн үнэлгээ, JORC стандартад нийцсэн хайгуулын ажлын төлөвлөгөө.</li> <li>- Хагас үйлдвэрлэлийн технологийн туршилтын тайлан.</li> <li>- Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нөөцийн ангилалд нийцсэн, ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцэгдэн баталгаажсан тайлан болон олон улсын</li> </ul>



		нөөц баялгийн /JORC/ стандартад нийцүүлсэн үр дүнгийн хянан баталгаажсан тайлан - Хянан баталгаажуулалт хийсэн мэдээллийн сан (collar, survey, lithology, assay), нөөцийн загварчлал (block model)
--	--	---


2024.01.15

**Хянасан:**


Үйлдвэр, технологийн бодлогын газрын ахлах менежер:

 Д.Даваадорж - 2

Төслийн судалгаа, үнэлгээний газрын ахлах менежер:


 Я.Өлзийболд

Асгат төслийн нэгжийн зохицуулагч:

 Б.Акжол


**Боловсруулсан:**

Геологич:









Ч.Буянбаатар

Геологич:







Э.Энхбаяр



Хэвтээ малталт 1	
Дээрээс харсан байдал	Гурван хэмжээст байдлаар
	
Хэвтээ малталтын нийт урт нь 3114.9 м	Байрших өндөр 2887.5 м
Хэвтээ малталт 2	
Дээрээс харсан байдал	Гурван хэмжээст байдлаар
	
Хэвтээ малталтын нийт урт нь 2020.7 м	Байрших өндөр 2978.4 м
Хэвтээ малталт 3	
Дээрээс харсан байдал	Гурван хэмжээст байдлаар
	
Хэвтээ малталтын нийт урт нь 846.5 м	Байрших өндөр 3083.7 м
Хэвтээ малталт 4	
Дээрээс харсан байдал	Гурван хэмжээст байдлаар




	
Хэвтээ малталтын нийт урт нь 995.4 м	Байрших өндөр 3179 м
<b>Хэвтээ малталт 5</b>	
Дээрээс харсан байдал	Гурван хэмжээст байдлаар
	
Хэвтээ малталтын нийт урт нь 1642.2 м	Байрших өндөр 2880.9 м



Нөөцийн дэвсгэр зураг

Хавсралт №2





№	Тайлангийн нэр	Огноо	Зохиогч	Хэл
<b>Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан</b>				
1	Результаты общих поисков в Юстыдском рудном районе и поисково-ревизионных работ в Монголо-Алтайской структурно-формационной зоне, проведенных в 1981-1982 гд	1984	Д.Баатар	Орос
2	Отчет о результатах поисково-оценочных работ на месторождении серебра Асхатин, выполненных в 1983-1987	1987	Х.Далилхан, Н.П.Бедарев, А.Аманбек, Б.Пүрэвжав	Орос
3	Отчет о результатах предварительной разведки и поисково-месторождении с подсчетом запасов по состоянию на 1июня 1991 года	1991	В.П.Грязнов, Е.И.Мошков, И.П. Гиниевский	Орос
4	Дополнение к отчету о результатах предварительной разведки и поисково-оценочных работ на Асгатском серебряном месторождении с подсчетом запасов по состоянию на 1.1.1996 года	1996	А.Аманбек, С.Жарганат	Орос
5	Заключение по результатам поисков подземных вод для водоснабжения горнодобывающего предприятия Асгат	1990	"Совгео" МНР	Орос
6	Асгатын мөнгөний ордын 1991 онд хийж гүйцэтгэсэн эрэл-үнэлгээ урьдчилсан хайгуулын ажлын үр дүнгээр тооцсон нөөцийн шинэчилсэн тайлан	2021	СТИЙЛ АЙРОН ХХК	Монгол
<b>ТЭЗҮ</b>				
1	Концептуальное технико-экономическое обоснование целесообразности освоения месторождения серебра Асгат	1995	Apex Silver Mines LDS, APEX ASIA LDS	Орос/Мо нгол орчуулга
2	Технико-экономический расчет (ТЭР) целесообразности освоения месторождения Асгат	1998	Сибгипрозолото	Орос/Мо нгол орчуулга
3	Пояснительная записка по освоению месторождения <Асгат> в северо-западной Монголии	2003	В.З.Козин, Б.Н.Кравец	Орос/Мо нгол орчуулга
<b>Туршилт, судалгаа</b>				
1	Разработка технологической схемы на основе применения новых селективных реагентов обогащения сложных мышьяк-содержащих медно-сурьмяно-серебряных руд асгатского месторождения с получением кондиционных концентратов	1994	Комитет российской федерации по металлургии	Орос/Мо нгол орчуулга
2	Results of Preliminary Laboratory Flotation Testing on a Copper-Silver bearing Ore Sample from Mongolia	1996	APEX ASIA, Dawson metallurgical Laboratories, INC	Англи/Мо нгол орчуулга
3	Отработка параметров сухой технологии получения коллективных концентратов из руд асхатинского месторождения	1999	Мария-Трэйд	Орос/Мо нгол орчуулга



4	Технологический регламент обогащения руды месторождения "Асгат"	1999	Мария-Трэйд	Орос/Монгол орчуулга
5	Отчет определение возможностей выделения сурьмы из коллективных концентратов месторождения Асгат	2002	Мария-Трэйд	Орос/Монгол орчуулга
6	"АСГАТ"-ын мөнгө-холимог металлын хүдрийн дээжийг баяжуулах технологийн туршилтын тайлан болон Монгол Улсын "Асгат" мөнгө-зэсийн уурхайн хөгжүүлэлтийн урьдчилсан төлөвлөлт	2021	Геологийн төв лаборатори ТӨҮГ, Yantai Jingpeng Mining Machinery Co.,Ltd	Хятад/Монгол
<b>Бусад тайлан</b>				
1	Asgat Evalution-Final report	1995	Simons LTD, Dentonia Resources Ltd	Англи